



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 01-А/300

Дархан

Дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан-Уул аймагт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 1/3099 дүгээр чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төв”-ийг байгуулах төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Төслийн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга

Аймгийн Засаг дарга

Гишүүд:

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Боловсрол, соёл урлагийн газрын дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
Мэргэжлийн хяналтын газрын дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн зөвлөлийн тэргүүн

Нарийн бичгийн дарга

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хүргүүлсэн чиглэлийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, төслийн ажлын явцыг улирал тутам холбогдох газарт тайлагнахыг Төслийн дэд хороонд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Т.ГАНБОЛД

0101001060